



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/419

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээ авах журам”-ыг нэгдүгээр, “Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдлийг магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээ авах журам”-ыг хоёрдугаар, “Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эхийн болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг эмгэг судлалын шинжилгээнд оруулах журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар ханган ажиллахыг Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газар (М.Наранпүрэв), мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (Ж.Отгонбаатар), Эмгэг судлалын үндэсний төв (Б.Ганзориг), Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Б.Болорчимэг), Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Ш.Энхтөр), Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөл (Э.Баярмаа)-д тус тус даалгасугай.

3. Журмыг мөрдөж ажиллахыг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/550 дугаар тушаал, “Эмнэлгийн нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх тухай” 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/263 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-т даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141252148

**Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг
магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээ авах журам**

Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээ авах зөвлөл нь (цаашид “Зөвлөл” гэх) эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг байгууллага, аймаг/нийслэл, үндэсний түвшинд хэлэлцэж, эхийн ноцтой хүндрэл, эндэгдлийн шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлсийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

Үндэсний түвшинд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн яамны эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл нь эхийн эндэгдэл, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдолд дүн шинжилгээ хийж, үр дүнг хагас, бүтэн жилээр Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Нэг. Зөвлөлийн үйл ажиллагаа

1.1. Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээ авах зөвлөлийг эмнэлгийн захирлын/даргын тушаалаар, Аймаг/Нийслэлийн зөвлөлийг эрүүл мэндийн газрын даргын тушаалаар байгуулна.

1.2. Байгууллага, Аймаг/Нийслэлийн зөвлөл нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын “Байгууллагад суурилсан эхийн болон перинатал эндэгдлийг хянах” аргачлалаар, эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийн тохиолдлыг эмгэг судлалын шинжилгээний эцсийн онош, дүгнэлт гарснаас хойш 15-30 хоногийн дотор хэлэлцэн, тухайн тохиолдолд холбогдох бүх бичиг баримтыг судалж, нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох, шалтгаан үр дагаврыг шинжилж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан, хариу арга хэмжээг тусламж үйлчилгээний чанар, удирдлагын дотоод хяналттай нягт уялдуулж, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.3. Зөвлөл нь зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, үр дүнг нээлттэй тайлагнах замаар эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдэлд нөлөөлсөн урьдчилан сэргийлж болох шалтгаан, хүчин зүйлсийг бууруулах, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ.

1.4. Эх эмнэлгийн бус нөхцөлд эсвэл эмнэлэгт ирснээс хойш 24 цагийн дотор эндсэн тохиолдолд өрх, сумын эмч, чанарын менежер нь эхийн гэр бүлийн гишүүд, холбогдох бусад хүмүүстэй харилцан ярилцаж, үгээр шинжих аргаар эндэгдлийн шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, хожимдлын талаар судалж, эхийн эндэгдлийн материалд хавсаргана.

Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг

2.1. Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг тогтоосон хугацаанд хэлэлцэж;

- Тухайн тохиолдол нь эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдэл мөн эсэхийг нягтална;
- Шалтгаан, үр дагаврын шинжилгээг хийж, нөлөөлсөн хүчин зүйлийг эрэмбэлэн, үр дүнг хэлэлцэж, хариу арга хэмжээг төлөвлөнө;
- Хожимдол, оношийн зөрөө байсан эсэхийг тогтооно;
- Нөлөөлсөн хүчин зүйлсийг тогтоож, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах асуудлаар цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж гаргана;
- Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг (Ухаалаг зарчмаар) боловсруулж, хэрэгжилтийг хянан, тайлан гаргаж, үр дүнг тархаана.
- Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийн тохиолдолд холбогдох бүх материалыг 2 хувиан (тухайн байгууллагын тамгаар баталгаажуулсан хариу арга хэмжээний төлөвлөгөө, шалтгаан, үр дагаврын шинжилгээний зураглал, багийн гишүүдийн үнэлгээний дүн, хурлын зөвлөмж, шийдвэрийн хамт) Эрүүл мэндийн яамны Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлд (эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдэл), Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлд (нярайн эрт үеийн эндэгдэл), Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд албан тоотоор ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.
- Баталгаажуулсан хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тархаасан тайланг Эрүүл мэндийн яамны эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэнд болон хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэнд, Эрүүл мэндийн яамны эх барих, эмэгтэйчүүд судлал болон хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлд албан тоотоор улирал тутам (дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор) хүргүүлнэ.

2.2. Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг

- Тухайн жилд бүртгэгдсэн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдэлд нөлөөлсөн гол хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээний хүрээнд зайлшгүй шаардлагатай бодлого, стратегийг тодорхойлж, үйл ажиллагааны төсөв, нөөцийг хуваарилна.
- Эхийн эндэгдэлд нөлөөлсөн шалтгаан, хүчин зүйлсийг бууруулах зорилгоор ажлын хэсгүүд байгуулан, эмнэлзүйн заавар боловсруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь байгууллага, орон нутгийн түвшинд ажиллаж буй зөвлөлийн гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангах, салбар зөвлөлийн хариу арга хэмжээний ухаалаг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх ажлыг удирдана.
- Орон нутгаас ирүүлсэн мэдээ мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийн, жилийн тайлан гаргаж, Эрүүл мэндийн яамны цахим сүлжээ, веб хуудсаар тархаахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

2.3. Аймаг, Дүүргийн зөвлөлийн эрх, үүрэг

- Үндэсний хэмжээнд гаргасан бодлого, удирдамжийг тухайн аймаг, дүүрэг, сум, эмнэлгийн түвшинд бодитоор хэрэгжүүлнэ;
- Байгууллагын зөвлөлөөс ирүүлсэн мэдээ, мэдээллийг нэгтгэж, үндэсний зөвлөлд тайланг илгээнэ;
- Байгууллагын хүрээнд хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Гурав. Зөвлөлийн гишүүдийн ёс зүйн дүрэм

3.1. Зөвлөлийн дарга, нарийн бичиг, гишүүд нь зөвлөлийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө. Гишүүн бүр зөвлөлийн ёс зүйн дүрэмтэй танилцаж, зөвшөөрч буйг гарын үсгээр баталгаажуулна.

3.2. Зөвлөлийн гишүүдийн ёс зүйн хэм хэмжээ:

- Хэлэлцүүлгийн явцад хэн нэгнийг нэрлэхгүй, буруутгахгүй байх соёлыг чанд баримтална;
- Хуралд цагтаа ирж, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоно;
- Хүн бүрийн үзэл санаа, түүнийг илэрхийлэх арга замыг хүндэтгэнэ;
- Хэлэлцүүлгийн явцад санал зөрөлдсөн тохиолдолд хүлээцтэй хандана;
- Хэлэлцэж буй мэдээллийн нууцлалыг чандлан хадгална;
- Хэлэлцэж буй тохиолдлын мэдээллийн үнэн бодит байдлыг (нуун дарагдуулахгүй, хуурамчаар мэдээлэхгүй байх) хангана.
- Зөвлөлийн гишүүд нь ёс зүйтэй, аливаа асуудалд сөрөг хандлага гаргахгүй, шийдвэр гаргах чадвартай мэргэжилтэн байна.

Дөрөв. Зөвлөлөөр хэлэлцэх асуудал

4.1. Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийн үзүүлэлт, чиг хандлагыг хэлэлцэнэ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг хэлэлцэх хугацаа, давтамж

№	Хэлэлцэх тохиолдол	Давтамж
1	Эхийн эндэгдэл	Тохиолдол гарсан тухай бүрд
2	Амьгүй төрөлт	Ижил төрлийн шалгаантай бол бүлэглэж хэлэлцэнэ
3	Нярайн эрт үеийн эндэгдэл	Нярайн эрт үеийн эндэгдэл гарсан тухай бүрд
4	Эхийн ноцтой хүндрэл	1 сарын дотор

4.2. Зөвлөлийн хурлын тэмдэглэл, баримтжуулалт

- Зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, дарга, нарийн бичиг, гишүүдийн гарын үсгээр баталгаажуулсан байна.
- Хурлаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг (Ухаалаг зарчмаар) боловсруулж батална.

- Өмнөх хурлын шийдвэрийн (төлөвлөгөөний) хэрэгжилтийг хурал болгоны өмнө хэлэлцэж, үр дүнг тооцож, хурлын тэмдэглэлд тусгана.
- Зөвлөл нь эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлагатай холбоотой асуудал, харьцаа хандлагын алдааг хэлэлцэхгүй. Хэрэв шаардлагатай гэж үзвэл Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба ба Ёс зүйн салбар хороонд шилжүүлэх санал дэвшүүлж болно.

Тав. Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээний зөвлөлийн бүрэлдэхүүн

5.1.1.Байгууллагын зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга: Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга (чанарын менежер) эсвэл Нөхөн үржихүйн ерөнхий зохицуулагч

Гишүүд:

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга;
 Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга;
 Эрүүл мэндийн газрын Эх барихын асуудал хариуцсан мэргэжилтэн;
 Эрүүл мэндийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
 Зөвлөх эмч (эх барих, эмэгтэйчүүд);
 Зөвлөх эмч (нярай);
 Эмнэлзүйч эмч;
 Эх баригч;
 Эмгэг судлалын онош, дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч (зөвшилцсөнөөр);
 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга (зөвлөлийн нарийн бичгийн даргаар сонгогдоогүй бол);
 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны менежер (зөвлөлийн нарийн бичгийн даргаар сонгогдоогүй бол);
 Нөхөн үржихүйн ерөнхий зохицуулагч (зөвлөлийн нарийн бичгийн даргаар сонгогдоогүй бол);
 Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч;
 Статистикийн тасгийн эрхлэгч;
 Нийгмийн ажилтан.

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна.

5.1.2.Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:	Эмнэлзүй хариуцсан тэргүүн дэд захирал
Зөвлөлийн дэд дарга:	Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг хариуцсан дарга Хүүхдийн эмнэлэг хариуцсан дарга
Нарийн бичгийн дарга:	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга
Гишүүд:	Сувилахуй эрхэлсэн дэд захирал; Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн чанарын менежер; Хүүхдийн эмнэлгийн чанарын менежер; Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн зөвлөх эмч нар; Хүүхдийн эмнэлгийн нярайн зөвлөх эмч нар; Төрөх тасгийн эрхлэгч; Төрсний дараах тасгийн эрхлэгч нар; Дутуу тээлт судлалын тасгийн эрхлэгч; Нярай судлалын тасгийн эрхлэгч нар; Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч; Статистик мэдээлэл зүйн тасгийн эрхлэгч, эмч; Эмгэг судлалын онош, дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч (зөвшилцсөнөөр).

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна.

5.2. Аймаг/Нийслэлийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Нийслэлд:

Зөвлөлийн дарга:	Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга эсвэл Эх барих, эмэгтэйчүүдийн болон Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Эрүүл мэндийн яамны Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2 гишүүн; Эрүүл мэндийн яамны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2 гишүүн; Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн; Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн;

Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн;
 Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга;
 Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлэг хариуцсан дарга;
 Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлэг хариуцсан дарга;
 Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга;
 Нийслэлийн Өргөө амаржих газрын Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга;
 Нийслэлийн Хүрээ амаржих газрын Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга;
 Нийслэлийн Амгалан амаржих газрын Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга;
 Эмгэг судлалын үндэсний төвийн Эх, хүүхдийн тасгийн эрхлэгч;
 Эмгэг судлалын онош, дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч (зөвшилцсөнөөр).

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна.

Аймагт:

Зөвлөлийн дарга:	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Эрүүл мэндийн газрын Эх барих, эмэгтэйчүүдийн болон Хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн; Эрүүл мэндийн яамны Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2 гишүүн; Эрүүл мэндийн яамны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2 гишүүн; Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга; Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн; Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга; Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга; Дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч;

Аймгийн Эрүүл мэндийн газрын Эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвлөлийн нарийн бичгийн даргаар сонгогдоогүй бол);

Аймгийн Эрүүл мэндийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвлөлийн нарийн бичгийн даргаар сонгогдоогүй бол);

Эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх эмч (зөвшилцсөнөөр);

Хүүхдийн зөвлөх эмч (зөвшилцсөнөөр);

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна.

5.3. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн:

Зөвлөлийн дарга: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Эрүүл мэндийн яамны Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн;
Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлийн 1 гишүүн;
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эх барих, эмэгтэйчүүдийн эмнэлгийн дарга;
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлгийн дарга;
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга;
Эмгэг судлалын үндэсний төвийн Эх, хүүхдийн тасгийн эрхлэгч;
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга;
Эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх зэрэгтэй эмч;
Эхийн эндэгдлийн шууд бус шалтгаантай тохиолдолд тухайн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн.

Жич: Тухайн тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн холбогдох эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжилтнүүдийг татан оролцуулна. Үүнд:

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга;

Тусламж, үйлчилгээ үзүүлсэн эмнэлгийн дарга эсхүл

Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга;

Байгууллагын чанар, аюулгүй байдлын албаны мэргэжилтэн;

Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

Тухайн орон нутгийг хариуцдаг зөвлөх эмч;

Тухайн эмнэлгийн эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх эмч эсхүл тасгийн эрхлэгч.

---oOo---

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
11-р сарын 12 өдрийн 4/4 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд
эндсэн эндэгдлийг магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээ авах журам**

Нэг. Ерөнхий зүйл

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдол бүрд тусламж үйлчилгээг чанартай, зөв үзүүлсэн эсэхийг хянаж, хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагаа юм.

Байгууллагын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө нь зөв боловч хэрэгжих арга зам нь тодорхой бус, мэдлэг, ур чадвар хангалтгүй, тушаал, шийдвэр, стандарт, заавар, журам, удирдамж мөрдөөгүй зэрэг удирдлага, зохион байгуулалт, эмнэлгийн тусламж үйлчилгээний болон эмч, мэргэжилтний мэдлэг, ур чадварын алдаа дутагдлыг дүгнэж, засаж залруулах, шуурхай арга хэмжээ авах, давтагдахаас сэргийлэх тогтолцоог эрүүл мэндийн байгууллага бүр хэрэгжүүлнэ.

Хоёр. Зорилго

Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн хурал нь эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд нөлөөлсөн хүчин зүйлс, шалтгааныг магадлан хэлэлцэж, дүн шинжилгээ хийж, алдаа дутагдлыг давтагдахаас сэргийлэх, цаашид авах арга хэмжээ, зохион байгуулах ажлыг төлөвлөж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх зорилготой.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагаа

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээний зөвлөл нь (цаашид “Зөвлөл” гэх) эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг байгууллага, аймаг/нийслэл, үндэсний түвшинд хэлэлцэж, хүүхдийн эндэгдлийн шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.

3.1. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээний Байгууллагын зөвлөлийг эмнэлгийн захирлын/даргын тушаалаар, Аймаг/Нийслэлийн зөвлөлийг Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар байгуулна.

3.2. Байгууллага, Аймаг/Нийслэлийн зөвлөл нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын “Байгууллагад суурилсан хүүхдийн эндэгдлийг хянах” аргачлалаар, хүүхдийн эндэгдлийн тохиолдлыг эмгэг судлалын шинжилгээний эцсийн онош, дүгнэлт гарснаас хойш 15-30 хоногийн дотор хэлэлцэн, тухайн тохиолдолд холбогдох бүх бичиг баримтыг судалж, нөлөөлсөн хүчин зүйлсийг тодорхойлох, шалтгаан үр дагаврыг шинжилж, нэгдсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан, хариу

арга хэмжээг тусламж үйлчилгээний чанар, удирдлагын дотоод хяналттай нягт уялдуулж, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3. Зөвлөл нь зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, үр дүнг нээлттэй тайлагнах замаар хүүхдийн эндэгдэлд нөлөөлсөн урьдчилан сэргийлж болох шалтгаан, хүчин зүйлсийг бууруулах, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааг удирдан чиглүүлнэ.

Дөрөв. Зөвлөлийн эрх, үүрэг

4.1. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг хэлэлцэх

- Шалтгаан, үр дагаврын шинжилгээг хийж, үр дүнг хэлэлцэж, хариу арга хэмжээг ухаалаг зарчмаар төлөвлөнө;
- Хожимдол, оношийн зөрөө байсан эсэхийг эцэслэн шийдвэрлэнэ;
- Эндэгдэлд нөлөөлсөн хүчин зүйлсийг тогтоож, тусламж үйлчилгээний чанарын асуудлыг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж гаргана;
- Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ухаалаг зарчмаар хэрэгжилтийг хянан, тайлан боловсруулж, үр дүнг тархаана;
- Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн материалыг 2 хувиан (тухайн байгууллагын тамгаар баталгаажуулсан хариу арга хэмжээний төлөвлөгөө, шалтгаан, үр дагаврын шинжилгээний зураглал, багийн гишүүдийн үнэлгээний дүн, хурлын зөвлөмж, шийдвэрийн хамт) Эрүүл мэндийн яамны хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөл, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Тандалт судалгааны албанд тус тус албан тоотоор 5 хоногийн дотор хүргүүлнэ;
- Баталгаажуулсан хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг тархаасан тайланг Эрүүл мэндийн яамны Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн яамны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлд тус тус албан тоотоор улирал тутам (дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор) хүргүүлнэ.

4.2. Үндэсний зөвлөлийн эрх, үүрэг

- Тухайн жилд бүртгэгдсэн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд нөлөөлсөн гол хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээний хүрээнд зайлшгүй шаардлагатай бодлого, стратегийг тодорхойлж, үйл ажиллагааны төсөв, нөөцийг хуваарилна.
- Эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэлд нөлөөлсөн шалтгаан, хүчин зүйлсийг бууруулах зорилгоор ажлын хэсгүүд байгуулан, эмнэлзүйн заавар боловсруулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь байгууллага, орон нутгийн түвшинд ажиллаж буй зөвлөлийн гишүүдийг мэргэжил арга зүйгээр хангах, салбар зөвлөлийн хариу арга хэмжээний Ухаалаг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх ажлыг удирдана.

- Орон нутгаас ирүүлсэн мэдээ мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, жилийн тайлан гаргаж, Эрүүл мэндийн яамны цахим сүлжээ, веб хуудсаар тархаахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.

4.3. Аймаг, Дүүргийн зөвлөлийн эрх, үүрэг

- Үндэсний хэмжээнд гаргасан бодлого, удирдамжийг тухайн аймаг, дүүрэг, сум, эмнэлгийн түвшинд бодитоор хэрэгжүүлнэ;
- Байгууллагын зөвлөлөөс ирүүлсэн мэдээ, мэдээллийг нэгтгэж, үндэсний зөвлөлд тайланг илгээнэ;
- Байгууллагын хүрээнд хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Тав. Зөвлөлийн гишүүдийн ёс зүйн дүрэм

5.1. Зөвлөлийн дарга, нарийн бичиг, гишүүд нь зөвлөлийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдөнө. Гишүүн бүр зөвлөлийн ёс зүйн дүрэмтэй танилцаж, зөвшөөрч буйг гарын үсгээр баталгаажуулна.

5.2. Зөвлөлийн гишүүдийн ёс зүйн хэм хэмжээ

- Хэлэлцүүлгийн явцад хэн нэгнийг нэрлэхгүй, буруутгахгүй байх соёлыг чанд баримтална;
- Хуралд цагтаа ирж, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоно;
- Хүн бүрийн үзэл санаа, түүнийг илэрхийлэх арга замыг хүндэтгэнэ;
- Хэлэлцүүлгийн явцад санал зөрөлдсөн тохиолдолд хүлээцтэй хандана;
- Хэлэлцэж буй мэдээллийн нууцлалыг чандлан хадгална;
- Хэлэлцэж буй тохиолдлын мэдээллийн үнэн бодит байдлыг (нуун дарагдуулахгүй, хуурамчаар мэдээлэхгүй байх) хангана.
- Зөвлөлийн гишүүд нь ёс зүйтэй, аливаа асуудалд сөрөг хандлага гаргахгүй, шийдвэр гаргах чадвартай мэргэжилтэн байна.

Зургаа. Зөвлөлөөр хэлэлцэх асуудал

6.1. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн үзүүлэлт, чиг хандлагыг хэлэлцэнэ.

6.2. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг улирал тутам хэлэлцэнэ.

6.3. Зөвлөлийн хурлын тэмдэглэл, баримтжуулалт

- Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтөлж, дарга, нарийн бичиг, гишүүдийн гарын үсгээр баталгаажуулна.
- Хурлаас гарсан зөвлөмжийг хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг (Ухаалаг зарчмаар) батална.
- Өмнөх хурлын шийдвэрийн (төлөвлөгөөний) хэрэгжилтийг хурал болгоны өмнө хэлэлцэж, үр дүнг тооцож, хурлын тэмдэглэлд тусгана.
- Зөвлөл нь эмнэлгийн мэргэжилтний ажлын хариуцлагатай холбоотой асуудал, харьцаа хандлагын алдааг хэлэлцэхгүй. Хэрэв шаардлагатай гэж үзвэл Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба ба Ёс зүйн салбар хороонд шилжүүлэх шийдвэр гаргаж болно.

Долоо. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх, хариу арга хэмжээний зөвлөлийн бүрэлдэхүүн

7.1.1. Байгууллагын зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга: Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга (чанарын менежер) эсвэл Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга;
Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга;

Эрүүл мэндийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвлөлийн нарийн бичгийн даргаар сонгогдоогүй бол);

Зөвлөх эмч (нярай);

Эмнэл зүйч эмч;

Сувилагч;

Эмгэг судлалын онош, дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч (зөвшилцсөнөөр);

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга (зөвлөлийн нарийн бичгийн даргаар сонгогдоогүй бол);

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны менежер (зөвлөлийн нарийн бичгийн даргаар сонгогдоогүй бол);

Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч;

Статистикийн тасгийн эрхлэгч.

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна.

7.1.2. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга: Эмнэлзүй хариуцсан тэргүүн дэд захирал

Зөвлөлийн дэд дарга: Хүүхдийн эмнэлгийн дарга

Нарийн бичиг: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга

Гишүүд: Сувилахуй эрхэлсэн дэд захирал
Хүүхдийн эмнэлгийн чанарын менежер;
Хүүхдийн эмнэлгийн нярайн зөвлөх эмч нар;
Нярай судлалын тасгийн эрхлэгч нар;
Эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч;
Холбогдох тасгийн эрхлэгч нар;
Статистик мэдээлэл зүйн тасгийн эрхлэгч;

Статистик мэдээлэл зүйн тасгийн эмч;
Эмгэг судлалын онош, дүгнэлт гаргасан анатомийн эмгэг
судлаач эмч (зөвшилцсөнөөр).

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна.

7.2. Аймаг/Нийслэлийн зөвлөлийн бүрэлдэхүүн

Нийслэлд:

Зөвлөлийн дарга:	Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга эсвэл Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Эрүүл мэндийн яамны хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2 гишүүн; Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн; Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн Хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн; Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга; Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлгийн дарга; Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв II-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга; Нийслэлийн Өргөө амаржих газрын Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга; Нийслэлийн Хүрээ амаржих газрын Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга; Нийслэлийн Амгалан амаржих газрын Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга; Эмгэг судлалын үндэсний төвийн Эх, хүүхдийн тасгийн эрхлэгч;

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна.

Аймагт:

Зөвлөлийн дарга	Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Аймгийн Эрүүл мэндийн газрын Хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
Эрүүл мэндийн яамны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2 гишүүн;
Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээ хариуцсан дарга;
Аймгийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн;
Аймгийн Эрүүл мэндийн газрын Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн;
Аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга;
Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга;
Эмгэг судлалын онош, дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч (зөвшилцсөнөөр);
Хүүхдийн зөвлөх эмч (зөвшилцсөнөөр).

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна.

8.3. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн:

Зөвлөлийн дарга: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга;

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

Гишүүд: Эрүүл мэндийн яамны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн ерөнхий мэргэжилтэн;
Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлийн 1 гишүүн;
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн эмнэлгийн дарга;
Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга;
Эмгэг судлалын үндэсний төвийн Хүүхдийн тасгийн эрхлэгч;
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга;
Хүүхэд, нярайн зөвлөх зэрэгтэй эмч.

Жич: Тухайн тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн холбогдох эрүүл мэндийн байгууллагуудын мэргэжилтнүүдийг татан оролцуулна. Үүнд:

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга;
Тусламж, үйлчилгээ үзүүлсэн эмнэлгийн дарга эсхүл
Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга;
Байгууллагын чанар, аюулгүй байдлын албаны
мэргэжилтэн;
Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан
мэргэжилтэн;
Тухайн орон нутгийг хариуцдаг зөвлөх эмч;
Тухайн эмнэлгийн хүүхэд, нярайн зөвлөх эмч эсхүл
тасгийн эрхлэгч

---oOo---

**Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эхийн болон тав хүртэлх насны хүүхдийн
эндэгдлийг эмгэг судлалын шинжилгээнд оруулах журам**

1. Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эхийн болон тав хүртэлх насны хүүхдийн цогцост анхны үзлэг хийсэн эмч гадны нөлөө байгаа эсэхэд дүгнэлт өгч, цогцостой холбоотой эрүүл мэндийн бичиг баримтыг ар гэрийнхнээс нь авч холбогдох байгууллагад хүлээлгэн (Өрхийн эрүүл мэндийн төв, Сумын эрүүл мэндийн төв гэх мэт) өгнө.

2. Тухайн тохиолдол нь гадны нөлөөтэй байвал цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ, нөлөөгүй гэж үзсэн тохиолдолд оршин суугаа нутаг дэвсгэрийн эмнэлгийн байгууллагын цогцос хадгалах газарт түргэн тусламжийн төвийн машинаар зөөвөрлөн хүргэнэ.

3. Тухайн тохиолдол нь гадны нөлөөгүй бол задлан шинжилгээг анатомийн эмгэг судлаач эмч хийх ба гадны шалтгааны улмаас нас барсан, гэмт хэргийн шинжтэй бол цагдаагийн байгууллагын шийдвэрээр Хууль зүй дотоод хэргийн яамны харьяа Шүүх шинжилгээний ерөнхий газрын, Шүүх анагаах ухааны шинжилгээний албаны шинжээч эмч хийнэ.

4. Нийслэлийн хэмжээнд эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эхийн болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгааныг тогтоох задлан шинжилгээг Эмгэг судлалын үндэсний төвийн хүүхдийн эмгэг судлалын тасагт хийнэ.

5. Орон нутагт эмнэлгийн бус нөхцөлд эх эндсэн тохиолдолд тухайн байгууллага нь Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Эмгэг судлалын үндэсний төвд дуудлага өгч, Эмгэг судлалын үндэсний төвөөс томилогдсон мэргэшсэн анатомийн эмгэг судлаач эмч, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлгийн анатомийн эмгэг судлаач эмч нартай хамтарсан багаар задлан шинжилгээнд орж, үндсэн өвчин, хүндрэл, үхлийн шалтгааныг тодорхойлж, онош, дүгнэлтийг гаргана.

6. Орон нутагт эмнэлгийн бус нөхцөлд тав хүртэлх насны хүүхэд эндсэн тохиолдолд тухайн байгууллага нь Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлэгт дуудлага өгч, анатомийн эмгэг судлаач эмч задлан шинжилгээнд орж, үндсэн өвчин, хүндрэл, үхлийн шалтгааныг тодорхойлж, онош, дүгнэлтийг гаргана.

7. Эмгэг судлалын үндэсний төв болон Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлгээс эмгэг судлалын тусламж, үйлчилгээ авах шаардлагатай тохиолдолд хүсэлт илгээж, анатомийн эмгэг судлаач эмчийг ажиллуулахдаа байр, хоол, унаа, томилолтын зардлыг тухайн эрүүл мэндийн байгууллага хариуцна.

8. Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эхийн болон тав хүртэлх насны хүүхдийн цогцсыг 24 цагийн дотор шинжилгээнд хамруулна.

9. Анатомийн эмгэг судлаач эмч нь эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдэлтэй холбоотой бүх баримттай танилцаж, задлан шинжилгээний дүгнэлтийг хуанлийн

21 хоногийн дотор гаргаж холбогдох эрүүл мэндийн байгууллагад хүргүүлж, эмнэлзүй эмгэг судлалын хуралд оролцоно.

---oOo---